



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

98.	Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/	293
99.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	319
100.	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	319
101.	Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	320
102.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	320
103.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	321
104.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	321
105.	Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	322
106.	Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	322
107.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	323
108.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /Шинэчилсэн найруулга/	324
109.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	341
110.	Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	342



111.	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	342
112.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	343
113.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	344
114.	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	345
115.	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	345
116.	Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	346
117.	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	347
118.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	347
119.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	348
120.	Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	348
121.	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	349
122.	Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	349
123.	Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	350
124.	Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	350

125.	Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	351
126.	Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	351
127.	Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	352
128.	Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	353
129.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	353
130.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	354
131.	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай	355
132.	Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	355
133.	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	356
134.	Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	356
135.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	357
136.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	359
137.	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	359
138.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	360



139.	Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		361
140.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		364
141.	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		366
142.	Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		366
143.	Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай		367
144.	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		369
145.	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		376
146.	Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр соёрхон батлах тухай		377
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
147.	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 12	377
148.	“Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 35	386
149.	“Тацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 37	386



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

150. Улсын ерөнхий прокурорыг  
томилох тухай Дугаар 26 387

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

151. Хөрөнгө оруулалтын тухай, Монгол Улсын  
Их Хурлын тухай, Төсвийн тогтвортой байдлын  
тухай, Онц байдлын тухай, Хүний хөгжил  
сангийн тухай, Ард нийтийн санал асуулгын  
тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль  
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай Дугаар 02 387

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ**

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн албан журмын даатгалын зарчим, хамрах хүрээг тогтоож, Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу даатгуулж шимтгэл төлөх, даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, төр, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.



## **2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж**

2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Эрүүл мэндийн тухай<sup>2</sup>, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай<sup>3</sup>, Даатгалын тухай<sup>4</sup>, Нийгмийн даатгалын тухай<sup>5</sup>, Нийгмийн халамжийн тухай<sup>6</sup>, Төрийн хяналт шалгалтын тухай<sup>7</sup>, Төрийн аудитын тухай<sup>8</sup>, Төсвийн тухай<sup>9</sup>, Хүний хөгжил сангийн тухай хууль<sup>10</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

## **3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “эрүүл мэндийн даатгал” гэж төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг;

3.1.2. “даатгуулагч” гэж энэ хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж, эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг;

3.1.3. “эрүүл мэндийн даатгалын байгууллага” гэж эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Нийгмийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup>Нийгмийн халамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Төрийн хяналт шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup>Төрийн аудитын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>10</sup>Хүний хөгжил сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.



3.1.4. “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага” гэж эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага болон эмийн санг;

3.1.5. “эрүүл мэндийн даатгалын шимтгэл” гэж эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон түүний нэрийн өмнөөс төр, хуулийн этгээд эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх төлбөрийг;

3.1.6. “эрүүл мэндийн даатгалын сан” гэж даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн, хуулийн этгээдээс төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг;

3.1.7. “эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц” гэж даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг;

3.1.8. “даатгалын гэрээ” гэж эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээг;

3.1.9. “төлбөрийн арга” гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх тооцооны хэлбэрийг;

3.1.10. “цахим карт” гэж даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас даатгуулагчид олгох цахим гэрчилгээг;

3.1.11. “эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгал” гэж иргэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ авахын тулд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус өмчийн даатгалын байгууллагад сайн дураар даатгуулахыг.

#### **4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын төрөл**

4.1. Эрүүл мэндийн даатгал нь албан журмын болон сайн дурын нэмэлт даатгал гэсэн төрөлтэй байна.



4.2.Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна.

4.3.Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна.

4.4.Энэ хуулийн 4.3-т зааснаас бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн өөрөө хүсвэл эрүүл мэндийн албан журмын даатгалд даатгуулж болно.

4.5.Эрүүл мэндийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын байгууллага эрхэлнэ.

4.6.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ авах зорилгоор иргэн эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгалд даатгуулж болно.

4.7.Эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгалын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий төрийн бус өмчийн даатгалын байгууллага эрхэлнэ.

4.8.Эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгалын харилцааг энэ хууль болон Даатгалын тухай хуулиар зохицуулна.

## **5 дугаар зүйл. Эрүүл мэндийн албан журмын даатгалын зарчим**

5.1.Эрүүл мэндийн албан журмын даатгал /цаашид “эрүүл мэндийн даатгал”-гэх/ нь даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах эв санааны нэгдлийн зарчимд тулгуурлана.

5.2.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, нотолгоонд үндэслэсэн, чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй байна.

5.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, энэ хуулийн 3.1.4-т заасан байгууллага энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.





5.4.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг иргэн, төр, хуулийн этгээд энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцна.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГУУЛАГЧ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**

#### **6 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүн амын бүлэг**

6.1. Хүн амыг эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх байдлаас нь хамааруулан доор дурдсанаар ангилна:

6.1.1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажилтан;

6.1.2. хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;

6.1.3. малчин;

6.1.4. энэ хуулийн 4.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

6.1.5. 0-18 насны хүүхэд;

6.1.6. тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн;

6.1.7. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

6.1.8. хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;

6.1.9. их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч;

6.1.10. хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;

6.1.11. ял эдэлж байгаа ялтан;

6.1.12. энэ хуулийн 6.1.1-6.1.11-д зааснаас бусад иргэн.

#### **7 дугаар зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг**

7.1. Даатгуулагч нь дараах эрхтэй:

7.1.1. Эрүүл мэндийн чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ авах;



7.1.2.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг энэ хуулийн дагуу тогтоосон хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх;

7.1.3.эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас сонгож үйлчлүүлэх;

7.1.4.эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч бусад байгууллагаас эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл авах;

7.1.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өөрөө шууд төлсөн төлбөрийн баримтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гаргуулах;

7.1.6.эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/, эрүүл мэндийн даатгалын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага зэрэг эрх бүхий хуулийн этгээдэд гомдол гаргах, шийдвэрлүүлэх;

7.1.7.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөр, төлбөрийн хөнгөлөлтөд хяналт тавих;

7.1.8.энэ хуулийн 6.1.1-6.1.4, 6.1.9, 6.1.12-т заасан даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр нь тухайн жилийн дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч гишүүний зөвшөөрснөөр, түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах;

7.1.9.төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн бүртгэл, авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд цахим байдлаар хяналт тавих;

7.1.10.илүү төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг эргүүлэн авах, эсхүл дараа төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлд тооцуулах;

7.1.11.хууль тогтоомжид заасан бусад эрх.

## 7.2.Даатгуулагч дараах үүрэгтэй:

7.2.1.эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хугацаанд төлөх;



7.2.2.эрүүл мэндийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг үнэн зөв мэдүүлэх;

7.2.3.эрүүл мэндийн даатгалын байгууллага, улсын байцаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

7.2.4.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, ДААТГУУЛАГЧИД ҮЗҮҮЛЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

**8 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн  
хувь хэмжээ, төлөх журам**

8.1.Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл /цаашид “шимтгэл” гэх/-ийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар дараах байдлаар тогтооно:

8.1.1.энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар жил бүр;

8.1.2.энэ хуулийн 6.1.5, 6.1.9-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар жил бүр;

8.1.3.энэ хуулийн 6.1.1, 6.1.5, 6.1.9-д зааснаас бусад даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар жил бүр.

8.2.Шимтгэлийг дараах байдлаар эрүүл мэндийн даатгалын санд хариуцан төлнө:

8.2.1.энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн шимтгэлийг даатгуулагч, ажил олгогч тэнцүү хувь хэмжээгээр сар бүр;

8.2.2.энэ хуулийн 6.1.2-6.1.4, 6.1.12-т заасан даатгуулагч шимтгэлийг өөрөө улирал бүр, эсхүл жил бүр;

8.2.3.энэ хуулийн 6.1.5-6.1.8, 6.1.10-т заасан даатгуулагчийн шимтгэлийг улсын төсвөөс сар бүр;



8.2.4.энэ хуулийн 6.1.9-д заасан даатгуулагч шимтгэлийг өөрөө улирал бүр, эсхүл жил бүр;

8.2.5.энэ хуулийн 6.1.11-д заасан даатгуулагчийн шимтгэлийг хорих байгууллага сар бүр.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан даатгуулагчийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд дараах этгээд хариуцан төлүүлнэ:

8.3.1.энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийг ажил олгогч;

8.3.2.энэ хуулийн 6.1.3-т заасан даатгуулагчийг баг, хорооны Засаг дарга даатгагчтай байгуулсан гэрээний дагуу;

8.3.3.энэ хуулийн 6.1.9-д заасан даатгуулагчийг сургуулийн захиргаа;

8.3.4.энэ хуулийн 6.1.10-т заасан даатгуулагчийг цэргийн анги, нэгтгэл.

### **9 дүгээр зүйл.Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

9.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад дараах тусламж, үйлчилгээ хамаарна:

9.1.1.хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ;

9.1.2.амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ;

9.1.3.өдрийн эмчилгээ, үйлчилгээ;

9.1.4.хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ;

9.1.5.уламжлалт, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээ;

9.1.6.өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл;

9.1.7.өрх, сум, баг, аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт;



9.1.8. зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл;

9.1.9. өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ;

9.1.10. хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ;

9.1.11. жирэмсний 37 долоо хоногоос өмнөх ба төрсний дараах үеийн хавсарсан эмгэгийн эмчилгээ.

9.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тухайн шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг даатгуулагчид харьяалал харгалзахгүй үзүүлнэ.

9.3. Даатгуулагч өрх, сум, баг, аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршлийн эмийг худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.

9.4. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлолт хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.

9.5. Нийтийг хамарсан аян хэлбэрээр зохион байгуулсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЗАРДЛЫН ТӨЛБӨР**

**10 дугаар зүйл. Даатгалын гэрээ байгуулах**

10.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн



тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ.

10.2.Гэрээнд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төсөв, нэр төрөл, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн арга, төлбөрийн хэмжээ болон гэрээний хугацаа, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, гэрээг цуцлах нөхцөлийг тодорхой тусгасан байна.

10.3.Гэрээний үлгэрчилсэн загварыг Үндэсний зөвлөл батална.

### **11 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр**

11.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сан болон даатгуулагч хамтран хариуцан төлнө.

11.2.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон нийгмийн даатгалын, санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно.

11.3.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төсвийн сарын хуваарийг үндэслэн гүйцэтгэлээр тооцож олгох бөгөөд эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан гэрээний дагуу зардлын урьдчилгаа төлбөр олгож болно.

11.4.Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлын төлбөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилтийг бууруулах үндэслэл болохгүй.

### **12 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг нөхөн төлүүлэх**

12.1.Дараах зардлыг доор дурдсан этгээдээр нөхөн төлүүлнэ:

12.1.1.гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын



төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад;

12.1.2.эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас оношилгоо, эмчилгээний хүндрэл гарсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг даатгуулагчид.

### **13 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх, үүрэг**

13.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй:

13.1.1. даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх;

13.1.2. эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах;

13.1.3. даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай, түргэн шуурхай үзүүлэх, даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах;

13.1.4. даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх;

13.1.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтны буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг хууль тогтоомжийн дагуу нөхөн төлөх;

13.1.6. эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;

13.1.7. эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал боловсруулж Үндэсний зөвлөл дэх өөрийн төлөөлөөрөө дамжуулан шийдвэрлүүлэх;



13.1.8.даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, тариа, материалын зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох;

13.1.9.эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн хэмжээгээр даатгуулагчийн төлөх төлбөрөөс хасч тооцох;

13.1.10.эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

13.1.11.даатгуулагчид шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх болон бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, лавлагаа тусламж үзүүлж, эм тариа олгохыг хориглох;

13.1.12.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО**

#### **14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл**

14.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын байгууллага, аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгалын байцаагчаас бүрдэнэ.

14.2. Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.

14.3. Үндэсний зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана:

14.3.1. Засгийн газрыг төлөөлж санхүү, төсвийн, нийгмийн даатгалын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;

14.3.2. даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн гурван хүн;

14.3.3. ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлсөн байгууллагыг төлөөлж гурван хүн.





14.4.Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүдийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлөх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

14.5.Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

14.6.Үндэсний зөвлөл ажлын албатай байх бөгөөд ажлын албаны орон тоо, ажиллах дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

14.7.Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам нэмэгдэл цалин олгох бөгөөд цалингийн нэмэгдлийн дээд хэмжээг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.

14.8.Үндэсний зөвлөл дараах эрхтэй:

14.8.1.эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах;

14.8.2.эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банкинд хадгалуулах журмыг санхүү, төсвийн, нийгмийн даатгалын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанкны саналыг тус тус үндэслэн батлах;

14.8.3.эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банкинд хадгалуулах, Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээ, журмыг санхүү, төсвийн, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанкны саналыг тус тус үндэслэн батлах;

14.8.4.эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх;

14.8.5.эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шинжээч, даатгуулагч, хамтрагч талуудыг оролцуулсан байнгын болон түр ажиллагаатай ажлын хэсэг байгуулах, ажлын үр дүнг хэлэлцэх;



14.8.6.эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах;

14.8.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

14.9.Үндэсний зөвлөл дараах үүрэгтэй:

14.9.1.эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

14.9.2.эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх;

14.9.3.энэ хуулийн 9.1-д заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

14.9.4.даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар, энэ хуулийн 11.2-т заасан даатгуулагчийн төлөх төлбөрийн хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухай бүр тогтоох;

14.9.5.эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;

14.9.6.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

14.9.7.эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;

14.9.8.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.



14.10.Үндэсний зөвлөл нь улиралд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна.

14.11.Дараах үндэслэлээр Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг чөлөөлнө:

14.11.1.үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн, үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон;

14.11.2.хурлыг гурван удаа дараалан хүндэтгэх шалтгаангүйгээр тасалсан;

14.11.3.бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

14.11.4.гэмт хэрэгт холбогдож гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон;

14.11.5.төлөөлж байгаа тал нь эгүүлэн татсан;

14.11.6.гишүүн нас барсан болон хуулиар тогтоосон чөлөөлөх бусад үндэслэл.

14.12.Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг Үндэсний зөвлөлийн гуравны хоёроос доошгүй гишүүний бичгээр гаргасан, тодорхой шалтгаан бүхий хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурал үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

14.13.Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацааг дуусахаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд гаргана.

### **15 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын байгууллага, түүний удирдлага**

15.1.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбар, нэгж нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын удирдлагын доор үйл ажиллагаа явуулна.

15.2.Эрүүл мэндийн даатгалын байгууллагын даргыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.



15.3.Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга нь Төрийн албаны тухай хуулийн<sup>11</sup> 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.

15.4.Эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбарын даргыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад гурваас доошгүй жил ажилласан ажилтнаас сонгон шалгаруулж эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

15.5.Сумын эрүүл мэндийн даатгалын ажилтныг орон нутгийн салбарын дарга томилж, чөлөөлнө.

### **16 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын чиг үүрэг**

16.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

16.1.2. Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах;

16.1.3. Даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;

16.1.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ хуулийн 14.9.6-д заасан журмын дагуу зохион байгуулах;

16.1.5. Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт хяналт тавих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх талаар зөвлөмж, заавар өгөх;

16.1.6. Энэ хуулийн 14.9.1, 14.9.3-14.9.6-д заасан асуудлаар санал боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Үндэсний зөвлөлөөр шийдвэрлүүлэх;

<sup>11</sup>Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



16.1.7.эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавих;

16.1.8.эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

16.1.9.Үндэсний зөвлөл болон бусад эрх бүхий этгээдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээ, тооцоо, судалгаагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

16.1.10.эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлэх, даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн, өртөг зардал, шимтгэлийн хувь хэмжээ тогтооход шаардлагатай тооцоо, судалгаа хийх, санал боловсруулах, эрх бүхий этгээдэд уламжлан, шийдвэрлүүлэх;

16.1.11.эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

16.1.12.даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

16.1.13.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 20.1.3-т заасан урамшуулал олгох журмыг батлах;

16.1.14.даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэх, түүнийг хянах, төлбөр тооцоог гүйцэтгэх, маргааныг шийдвэрлэх журмыг батлах;

16.1.15.эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмыг батлах;

16.1.16.эрүүл мэндийн даатгалын асуудлаар журам, аргачлал, заавар гаргах;

16.1.17.даатгуулагчийг энэ хуулийн 9.4-т заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах товлолт хугацааг даатгуулагчид тухай бүр урьдчилан мэдэгдэж байх;

16.1.18.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.



16.2.Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг худалдан авах ажиллагааг эрүүл мэндийн даатгалын байгууллага гэрээний үндсэн дээр үе шаттайгаар гүйцэтгэнэ.

16.3.Энэ хуулийн 16.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.

### **17 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн эрх, үүрэг, хариуцлага**

17.1.Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад хоёроос доошгүй жил ажиллаж мэргэшсэн, мэргэжлийн өндөр зэрэгтэй ажилтанд эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга улсын байцаагчийн эрх олгож, түдгэлзүүлж, цуцална.

17.2.Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн ажиллах дүрмийг эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга батална.

17.3.Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч дараах эрх, үүрэгтэй:

17.3.1.даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбогдолтой өвчний түүх, эмнэлгийн карт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний бусад баримт бичигт хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа авах;

17.3.2.эрүүл мэндийн даатгалын хяналт шалгалтад шаардагдах баримт бичгийн хуулбарыг холбогдох байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулах;

17.3.3.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөр, үр дүнд хяналт тавих, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;

17.3.4.холбогдох стандарт, удирдамжийг зөрчиж даатгуулагчийн эрүүл мэндэд хохирол учруулах, хууль бус төлбөртэй эмчилгээ, тусламж, үйлчилгээ үзүүлэх зэргээр зөрчил гаргасан албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

17.3.5.эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн даатгалын харилцаанд оролцогч байгууллага, албан тушаалтан, даатгуулагч, иргэнд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэж, зөрчлийг давтан гаргасан этгээдийн үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх.



17.4.Шимтгэл төлөхтэй холбогдсон хууль бус үйл ажиллагааг нуух, эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг хувийн зорилгод ашиглах, авлига авах, ёс зүйн хэм хэмжээг зөрчих, мэдээллийн нууц задруулах, эрхээ хэтрүүлэх зэргээр албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй даатгалын улсын байцаагчид хууль тогтоомжид заасан сахилгын, захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

**18 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч, мэргэжилтний нийгмийн баталгаа, мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл**

18.1. Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч, мэргэжилтэн албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд нь дараах буцалтгүй тусламжийг олгоно:

18.1.1. хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

18.1.2. хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

18.1.3. амь насаа алдсан тохиолдолд гэр бүлд нь хохирогчийн гурван жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж.

18.2. Энэ хуулийн 18.1.3-т заасан буцалтгүй тусламжийг ажиллаж байсан байгууллага нь олгож, хуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

18.3. Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Үндэсний зөвлөл батална.

18.4. Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч, мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор мөнгөн тэтгэмж олгох бөгөөд мөнгөн тэтгэмж олгох журмыг Үндэсний зөвлөл батална.



**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН**

**19 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн  
орлогын эх үүсвэр**

19.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

19.1.1. даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

19.1.2. ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

19.1.3. төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл;

19.1.4. хуулийн дагуу Хүний хөгжил сангаас төлсөн төлбөр;

19.1.5. төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө;

19.1.6. сангийн чөлөөт үлдэгдлийн хүү;

19.1.7. эрсдэлийн нөөцийг хадгалуулсны хүү;

19.1.8. эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулсан алданги;

19.1.9. бусад эх үүсвэр.

19.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

19.3. Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

19.4. Нийгмийн даатгалын байгууллага төвлөрүүлсэн хөрөнгийг долоо хоног бүр эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлнэ.





## **20 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт**

20.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг доор дурдсан зориулалтаар зарцуулна:

20.1.1. энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах;

20.1.2. төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан худалдан авах;

20.1.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад олгох урамшууллын зардал;

20.1.4. энэ хуулийн 9.4-т заасан зардал;

20.1.5. эрүүл мэндийн даатгалын байгууллагын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний зардал;

20.1.6. эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал;

20.1.7. нийгмийн даатгалын байгууллагын энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааны зардал;

20.1.8. иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулахтай холбоотой мэдээлэл, сурталчилгааны зардал;

20.1.9. Үндэсний зөвлөлийн гишүүний энэ хуулийн 14.7-д заасан нэмэгдэл цалин болон ажлын албаны үйл ажиллагааны зардал.

20.2. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна.

20.3. Энэ хуулийн 20.1.6-20.1.9-д заасан зардал нь эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 5 хувиас илүүгүй байна.

20.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн анхан шатны нягтлан бодох бүртгэлийн маягтын загварыг санхүү, төсвийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.



20.5.Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан, түүнийг банкинд хадгалуулснаас олсон орлого, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр үүсэх эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдлыг нөхөж, уг сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 14.8.2, 14.8.3-т заасан журмын дагуу зарцуулна.

### **21 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийг батлах, тайлан тэнцэл гаргах**

21.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.

21.2.Үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

21.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийг Засгийн газарт мэдүүлнэ.

21.4.Засгийн газар эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

21.5.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын тайлан тэнцлийг доор дурдсан хугацаанд улирал, жилээр нэгтгэн гаргаж, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зөвлөлд тайлагнаж байна:

21.5.1.орлого, зарлагын тайланг сум, дүүргийн эрүүл мэндийн даатгалын байгууллага тухайн улирлын дараа сарын 15-ны дотор, аймгийн эрүүл мэндийн даатгалын байгууллага тухайн улирлын дараа сарын 25-ны дотор эрүүл мэндийн даатгалын байгууллагад тус тус ирүүлэх;

21.5.2.эрүүл мэндийн даатгалын байгууллага эрүүл мэндийн даатгалын сангийн улирлын нэгдсэн тайланг улирлын хоёр дахь сарын 10-ны дотор, жилийн нэгдсэн тайланг дараа оны 02 дугаар сарын 25-ны дотор тус тус нэгтгэн санал, дүгнэлтийн хамт нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;



21.5.3.нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улирлын тайланг дараа улирлын сүүлийн сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Үндэсний зөвлөлөөр хянан хэлэлцүүлэх.

21.6.Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

## **22 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сан, даатгуулагчийн цахим карт**

22.1.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагч, шимтгэл төлөлт, даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан /цаашид “мэдээллийн цахим сан” гэх/-тай байх бөгөөд мэдээллийн цахим сангийн дүрмийг Засгийн газар батална.

22.2.Мэдээллийн цахим сан нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулах ба эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ, хэтийн тооцоолол хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

22.3.Мэдээллийн цахим сан нь эрүүл мэндийн даатгалын байгууллагаас сонгосон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын жагсаалт, байршил, шатлал, үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо, чанарын баталгаажилтын талаарх мэдээллийг агуулна.

22.4.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид эрүүл мэндийн даатгалд даатгуулсныг гэрчлэх цахим карт олгоно.

22.5.Энэ хуулийн 22.4-т заасан цахим карт нь даатгуулагч энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад төлбөр гүйцэтгэх мэдээллийн хэрэгсэл болно.

22.6.Цахим картын загвар, цахим картад хадгалагдах мэдээлэл, цахим картыг хэрэглэх журмыг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.



**ДОЛООДУГААР БҮЛЭГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

**23 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний  
чанар болон төлбөрийн хяналт**

23.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтын үйл ажиллагаа эрхэлсэн нэгжтэй байна.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.2.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх;

23.2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн талаар даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, даатгуулагчийн эрхийг хамгаалах;

23.2.3. Хуулиар тогтоосон бусад чиг үүрэг.

23.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрт хяналт тавих, маргаан шийдвэрлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шинжээч, даатгуулагч, оролцогч, хамтрагч талуудтай хамтран ажиллана.

**24 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын  
үйл ажиллагаанд тавих хяналт**

24.1. Үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг жил бүр, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайланг улирал бүр хэлэлцэн холбогдох асуудлаар шийдвэр гаргана.

24.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дотоод хяналтын нэгжтэй байх ба дотоод хяналтын нэгжийн дүрмийг эрүүл мэндийн даатгалын байгууллага баталж мөрдөнө.



24.3.Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд төрийн болон хөндлөнгийн аудитын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

24.4.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд иргэн, хуулийн этгээд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлж болно.

### **25 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

25.1.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын байгууллага, түүний салбар нэгж, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

25.2.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

25.2.1.энэ хуулийн 6.1.2-6.1.4, 6.1.12-т заасан даатгуулагч шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол тухайн жилийн төлбөл зохих шимтгэлийг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

25.2.2.энэ хуулийн 8.3-т заасан байгууллага, албан тушаалтан үүргээ биелүүлээгүй тохиолдолд төлбөл зохих шимтгэлийг нөхөн төлүүлж, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

25.2.3.эрүүл мэндийн даатгалын санг хохироосон нь тогтоогдвол хохирлыг нөхөн төлүүлж, хувь хүнийг 30000-50000 төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

25.3.Эрүүл мэндийн даатгалын байгууллага энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг 14-өөс дээш хоногоор хугацаа хожимдуулсан бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад төлнө.



25.4.Ажил олгогч, ерөнхий менежер шимтгэлийг энэ хууль болон Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хугацаанд шилжүүлээгүй бол уг шимтгэлийг нөхөн төлүүлж, хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих шимтгэлийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

25.5.Энэ хуулийн 13.1-д заасныг зөрчсөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар хохирлыг нөхөн төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулах бөгөөд тухайн жилд энэ зөрчил давтагдвал эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын тухайн сарын төлбөрийн хэмжээг 10 хүртэл хувиар бууруулах, гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

25.6.Гэм буруутай этгээд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр, нөхөн төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдол гаргана.

### **26 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын бусад харилцааг зохицуулах**

26.1. Эрүүл мэндийн даатгалтай холбогдолтой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хуулийн заалтаар зохицуулна.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **27 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

27.1. Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, энэ хуулийн 8.1 дэх хэсэг, 8.2.4 дэх заалт, 15.1 дэх хэсгийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8.1 дэх хэсгийг хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

**2 дугаар зүйл.**2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6.1.9-д заасан даатгуулагч шимтгэлээ 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн өөрөө хариуцан төлөх бөгөөд 2016 оны 01 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд мөн хуулийн 6.1.9-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцан төлнө.

**3 дугаар зүйл.**2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15.1-д заасан эрүүл мэндийн даатгалын байгууллагын чиг үүргийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл нийгмийн даатгалын төв байгууллага хэрэгжүүлнэ.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2002 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “иргэний” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.4.36 дахь заалт:**

“5.4.36.Эрүүл мэндийн даатгалын сан.”

**2/6 дугаар зүйлийн 6.2.10 дахь заалт:**

“6.2.10.Эрүүл мэндийн даатгалын сан.”





**2 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын сан,” гэсний дараа “Эрүүл мэндийн даатгалын сан,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэсний дараа “болон эрүүл мэндийн даатгалын” гэж, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14 дэх заалтын “-нийгмийн даатгалын бодлого;” гэсний дараа “-эрүүл мэндийн даатгалын бодлого;” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.8 дахь заалтын “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн” гэсний дараа “болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн” гэж нэмсүгэй.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Эрүүл мэндийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ, шимтгэлийн хэмжээ болон эрүүл мэндийн даатгалтай холбогдсон бусад харилцааг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.51 дэх заалт нэмсүгэй:

“4.1.51.“эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв” гэж Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг.”



**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6, 8.8, 8.9 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтын “Нийгмийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэж, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэсний дараа “, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв” гэж, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “Нийгмийн даатгалын сангийн” гэсний дараа “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалт:**

“24.6.4.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, түргэн тусламж, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;”

**2/24 дүгээр зүйлийн 24.6.6 дахь заалт:**

“24.6.6.сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн зарим эмчилгээ;”

**3/24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг:**

“24.7.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, төлбөрийн



хэмжээ болон эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах эрүүл мэндийн байгууллагыг сонгох журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл батална.”

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “иргэний эрүүл мэндийн даатгал” гэснийг “эрүүл мэндийн даатгал” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн  
тухай хууль тогтоомж**

2.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Улсын бүртгэлийн ерөнхий

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг;

3.1.2.“хуулийн этгээдийн нэр” гэж улсын бүртгэлийн байгууллагаас баталгаажуулсан, хуулийн этгээдийг бусад хуулийн этгээдээс ялгах зорилгоор хэрэглэх нэрийг;

3.1.3.“хуулийн этгээдийн улсын бүртгэл” /цаашид “улсын бүртгэл” гэх/ гэж Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4.4-т заасныг;

3.1.4.“хуулийн этгээдийн хувийн хэрэг” гэж улсын бүртгэлийн мэдээллийн санд бичмэл хэлбэрээр байгаа, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан мэдээллийн бүрдлийг;

3.1.5.“үүсгэн байгуулах баримт бичиг” гэж эрх бүхий этгээдээс гаргасан хуулийн этгээд байгуулах шийдвэр, хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээг;

3.1.6.“хуулийн этгээдийн мэдээлэл” гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа үүсгэн байгуулах баримт бичиг болон бусад мэдээллийг;

3.1.7.“улсын бүртгэлийн байгууллага” гэж энэ хуульд заасан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар байгууллагыг;

3.1.8.“улсын бүртгэлийн мэдээллийн сан” гэж Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.4-т заасан бүртгэлийн бичмэл баримт бичиг бүхий архив, цахим мэдээллийн сангийн бүрдлийг;

---

<sup>3</sup>Улсын бүртгэлийн ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 26 дугаарт нийтлэгдсэн.



3.1.9.“бүртгэлийн цахим хэлбэр” гэж цахим сүлжээгээр дамжуулан улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудсанд хандаж улсын бүртгэл хийлгэхийг;

3.1.10.“улсын бүртгэлийн гэрчилгээ” гэж тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолж, улсын бүртгэлийн мэдээллийн санд байршуулсан, улсын бүртгэлийн байгууллагаас эрх бүхий этгээдэд цахим болон бичгийн хэлбэрээр олгох баримт бичгийг.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1.Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрээс үл хамааран иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.2.Энэ хуулийн зохицуулалтад гадаад улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газраас бусад хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хамаарахгүй.

#### **5 дугаар зүйл.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар үүсэх үндэслэл**

5.1.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

5.2.Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно.

5.3.Энэ хуулийн 5.2-т заасныг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд уг гэм хорыг арилгана.

#### **6 дугаар зүйл.Улсын бүртгэлийн үйлчилгээ авах хэлбэр**

6.1.Улсын бүртгэлийн үйлчилгээг энэ хуульд заасны дагуу цахим, эсхүл бичгийн хэлбэрээр авч болно.

#### **7 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хураамж**

7.1.Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн<sup>4</sup> 14, 15 дугаар зүйлд заасан хураамж төлнө.

<sup>4</sup>Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



7.2.Энэ хуулийн 16.1-д заасан өргөдөл гаргагч улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийг цахим хэлбэрээр төлж болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ**

### **8 дугаар зүйл.Улсын бүртгэлийн байгууллага**

8.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ:

8.1.1.нөхөрлөл;

8.1.2.компани;

8.1.3.хоршоо;

8.1.4.төрийн бус байгууллага;

8.1.5.төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар;

8.1.6.төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар;

8.1.7.шашны байгууллага;

8.1.8.хэвлэл мэдээллийн байгууллага;

8.1.9.нийтийн эрх зүйн хуулийн этгээд;

8.1.10.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж;

8.1.11.соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага;

8.1.12.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар.

8.2.Энэ хуулийн 8.1.6-д Засгийн газар хоорондын байгууллага, олон улсын байгууллага болон Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй.

8.3.Улсын дээд шүүх улс төрийн намыг энэ хууль болон бусад хуульд заасны дагуу бүртгэнэ.

### **9 дүгээр зүйл.Улсын бүртгэлийн байгууллагын эрх, үүрэг**

9.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:



9.1.1.хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, энэ тухай хуульд заасны дагуу цахим хуудсаар нийтэд мэдээлэх;

9.1.2.хуулийн этгээд тус бүрд холбогдох мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хэвлэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргаж, архивт хүлээлгэн өгөх;

9.1.3.энэ хуулийн 10.5-д заасан журмын дагуу хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх;

9.1.4.хуулийн этгээдийн хувийн хэргээс энэ хуульд заасан журмын дагуу лавлагаа олгох;

9.1.5.хуулийн этгээдийн нэрийн сан хөтлөх, түүнээс лавлагаа олгох;

9.1.6.улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцох;

9.1.7.улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан бусад шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, тэдгээрийг боловсронгуй болгох талаар саналаа холбогдох байгууллагад гаргах;

9.1.8.иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавьж, лавлагаа олгох;

9.1.9.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг холбогдох журмын дагуу шинээр бүртгэх, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах, улсын бүртгэлээс хасах.

9.2.Энэ хуулийн 9.1.8, 9.1.9-д заасан харилцааг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

9.3.Улсын бүртгэлийн байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын тоо, тэдгээрийн эзэмшиж байгаа хувь, хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийн талаар нэгдсэн бүртгэл хөтөлж, энэ талаарх мэдээллийг хагас болон бүтэн жилээр гаргаж, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.





9.4.Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан журмын дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох зааврыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

9.6.Улсын бүртгэлийн байгууллага нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

9.7.Энэ хуулийн 9.6-д заасан цахим хуудсанд байршуулсан мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын албан ёсны мэдээлэл гэж үзнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВИЙН ХЭРЭГ**

### **10 дугаар зүйл.Хуулийн этгээдийн хувийн хэрэг бүрдүүлэх зарчим, хэлбэр**

10.1.Хуулийн этгээдийн хувийн хэрэг бүрдүүлэх зарчим, хэлбэр нэгдмэл байна.

10.2.Хуулийн этгээдийн хувийн хэргийг улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтлөхдөө улсын хэмжээний бусад мэдээллийн систем, сүлжээтэй харилцан уялдаатай байх зарчмыг удирдлага болгон зохих арга зүйг ашиглана.

10.3.Хуулийн этгээдийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар хөтөлнө.

10.4.Хуулийн этгээдийн хувийн хэргийг бичмэл хэлбэрээр бүрдүүлэхдээ холбогдох баримт бичгийг дугаарлан засвар оруулах боломжгүй байдлаар хадгална.

10.5.Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **11 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга**

11.1.Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна:



11.1.1.хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар;

11.1.2.хуулийн этгээдийн төрөл, хэлбэр;

11.1.3.хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг;

11.1.4.хуулийн этгээдийг шинээр байгуулсан, эсхүл өөрчлөн байгуулсан тухай;

11.1.5.үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;

11.1.6.үүсгэн байгуулах баримт бичиг;

11.1.7.өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын талаар;

11.1.8.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр;

11.1.9.компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

11.1.10.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, гадаадын иргэн бол хөрөнгө оруулагчийн биеийн байцаалт;

11.1.11.хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг.

11.2.Хуулийн этгээдийн хувийн хэрэг дэх мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд баримт бичгийн эх хувь болон өмнө нь орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг хэвээр хадгална.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

## **12 дугаар зүйл.Хуулийн этгээдийн хувийн хэргээс лавлагаа олгох**

12.1.Улсын бүртгэлийн байгууллага нь иргэний үнэмлэхийн болон хуулийн этгээдийн регистрийн дугаарын мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгч болно.



12.2.Хуулийн этгээдийн хувийн хэргийн лавлагааг дараах хэлбэрээр олгоно:

12.2.1.бичгээр, эсхүл цахим хэлбэрээр;

12.2.2.шаардлагатай гэж үзвэл холбогдох баримт бичгийн хуулбараар.

12.3.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн хувийн хэргээс лавлагаа авах тухай хүсэлт хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор холбогдох этгээдэд лавлагааг олгоно.

12.4.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн хувийн хэргээс лавлагаа олгохдоо Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19.2-т заасны дагуу Засгийн газраас тогтоосон үйлчилгээний хөлсийг мөрдөнө.

12.5.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр олгох лавлагаанд энэ хуулийн 12.4 дэх хэсэг хамаарахгүй.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШИНЭЭР БАЙГУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ**

#### **13 дугаар зүйл.Улсын бүртгэлд бүртгэх хугацаа**

13.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар ажлын 10 өдрийн дотор, бусад хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар ажлын хоёр өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

13.2.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагчид татгалзаж байгаа үндэслэл бүхий мэдэгдлийг бичгээр, цахим хэлбэрээр хүргүүлнэ.

13.3.Цахим хэлбэрээр өргөдөл гаргагч энэ хуулийн 13.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэх тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш энэ хуулийн 17.1-17.3-т заасан, эх хувь нь шаардлагатай баримт бичгийг өөрийн иргэний үнэмлэхийн хамт холбогдох улсын бүртгэлийн байгууллагад ажлын таван өдрийн дотор биечлэн авч ирснээр бүртгэл албан ёсоор баталгаажна.

13.4.Өргөдөл гаргагч энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлэхдээ гарын үсгээ Цахим гарын үсгийн



тухай хуульд<sup>5</sup> заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд энэ хуулийн 13.3 дахь хэсэг хамаарахгүй.

13.5.Хуулийн этгээд өөрчлөгдсөнөөр шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх хугацаа энэ хуулийн 13.1-д заасантай нэгэн адил байна.

#### **14 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах**

14.1.Шинээр, өөрчлөн байгуулах замаар шинээр хуулийн этгээд байгуулагдах болон хуулийн этгээдийн нэр өөрчлөх тохиолдолд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

14.2.Улсын бүртгэлийн байгууллага Иргэний хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу дараах ерөнхий шаардлагыг хангасан хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулна:

14.2.1.хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэртэй давхардаагүй;

14.2.2.хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан;

14.2.3.кирилл үсгээр илэрхийлэгдсэн;

14.2.4.бусад хуулиар хориглоогүй.

14.3.Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

14.4.Хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гаргаагүй бол хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хүчингүй болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг энэ хуульд заасны дагуу дахин гаргаж болно.

14.5.Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### **15 дугаар зүйл.Шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргах**

15.1.Өргөдөл гаргагч шинээр байгуулсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

<sup>5</sup>Цахим гарын үсгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



15.2.Өргөдөлд дараах үндсэн мэдээллийг тусгана:

- 15.2.1.өргөдөл гаргасан он, сар, өдөр;
- 15.2.2.хуулийн этгээдийн нэр;
- 15.2.3.энэ хуулийн 8.1-д заасан хуулийн этгээдийн хэлбэр;
- 15.2.4.хуулийн этгээдийн хаяг;
- 15.2.5.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн талаарх

мэдээлэл;

- 15.2.6.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- 15.2.7.эрхлэх үйл ажиллагааны чиглэл;
- 15.2.8.хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацаа;
- 15.2.9.өргөдөл гаргагчийн мэдээлэл.

15.3.Энэ хуулийн 16.1-д заасан өргөдөл гаргагч баталсан маягтын дагуу өргөдөл гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулах ба өргөдлийг цахим хэлбэрээр гаргасан бол цахим гарын үсгээр баталгаажуулж болно.

**16 дугаар зүйл.Өргөдөл гаргах эрх бүхий этгээд**

16.1.Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг өргөдөл гаргах эрх бүхий дараах этгээдийн аль нэг нь гаргаж болно:

- 16.1.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага;
- 16.1.2.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч;
- 16.1.3.хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх

бүхий албан тушаалтан;

16.1.4.хуулийн этгээд татан буугдах тохиолдолд татан буулгах комиссын дарга;

16.1.5.итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд.

**17 дугаар зүйл.Улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардах баримт бичиг**

17.1.Өргөдөл гаргагч шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- 17.1.1.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт;
- 17.1.2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- 17.1.3.үүсгэн байгуулах баримт бичиг;
- 17.1.4.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;
- 17.1.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.



17.2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь энэ хуулийн 17.1-д заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

17.2.1.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн<sup>6</sup> 21.1-д заасны дагуу гадаадын төрийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулагчаар оролцож байгаа бол гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр;

17.2.2.хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран байгуулж байгаа бол хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ;

17.2.3.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч нь гадаадын иргэн бол хөрөнгө оруулагчийн биеийн байцаалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын хилээр нэвтрэх эрх олгосон зөвшөөрөл, хуулийн этгээд бол гадаадын хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

17.2.4.гадаадын хөрөнгө оруулагч мөнгөн хөрөнгө, бэлэн мөнгө, хөдлөх эд хөрөнгө, оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийж байгаа бол гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны тодорхойлолт, дансны хуулга, гаалийн байгууллагын мэдүүлэг, эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг.

17.3.Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4-т заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь энэ хуулийн 17.1, 17.2-т заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

17.3.1.гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн тус бүрд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ;

17.3.2.гадаад улс дахь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бол тухайн байгууллагын зөвшөөрөл болон өргөдөл гаргагч нь тус байгууллагын гишүүн бөгөөд эрх олгосон болохыг нотолсон тодорхойлолт;

17.3.3.энэ хуулийн 17.3-т заасан хуулийн этгээд нь тухайн улсдаа хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

<sup>6</sup>Хөрөнгө оруулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.



17.4.Энэ хуулийн 17.1-17.3-т заасан баримт бичиг нь монгол хэлээр байх бөгөөд гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийг орчуулж, хавсаргана.

17.5.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага өргөдөл гаргагчаас энэ хуулийн 17.1-17.3-т зааснаас бусад баримт бичгийг шаардахгүй.

17.6.Улсын бүртгэлийн байгууллага нь өргөдлийг бичгээр хүлээн авсан бол баримт бичгийн жагсаалт, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут бүхий мэдээллийг өргөдөл гаргагчид цахим хэлбэрээр, эсхүл бичгээр хүргүүлнэ.

### **18 дугаар зүйл.Шинээр байгуулсан хуулийн этгээдийг бүртгэх**

18.1.Энэ хуулийн 13.1-д заасан улсын бүртгэлийн байгууллагын шийдвэр нь улсын бүртгэлийн мэдээллийн санд тухайн хуулийн этгээдийг бүртгэх, хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар олгох үндэслэл болно.

18.2.Цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.3-т заасны дагуу эх хувиар авч ирсэн баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлсэн баримт бичигтэй тулган нягталсны дараа тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудас дээр хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар, он, сар, өдөр бүхий баталгааны тэмдэг, бусад хуудас дээр улсын бүртгэгчийн тэмдэг дарснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.

18.3.Өргөдлийг бичгээр гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага эх баримтыг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулсны дараа тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудас дээр хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар, он, сар, өдөр бүхий баталгааны тэмдэг, бусад хуудас дээр улсын бүртгэгчийн тэмдэг дарснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.

18.4.Улсын бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн болон регистрийн дугаар бүхий улсын бүртгэлийн цахим гэрчилгээг өргөдөл гаргагч хэвлэн авах боломжтойгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд байршуулна.

18.5.Улсын бүртгэлийн байгууллага нь өргөдөл гаргагчийн хүсэлтээр улсын бүртгэлийн гэрчилгээг үнэт цаасан дээр хэвлэж, баталгаажуулан олгож болно.



18.6.Төрийн болон бусад байгууллага үйл ажиллагаандаа зөвхөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим гэрчилгээг ашиглана.

18.7.Улсын бүртгэлийн гэрчилгээний загварыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **19 дүгээр зүйл.Бүртгэхээс татгалзах**

19.1.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг дараах тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

19.1.1.улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу;

19.1.2.үүсгэн байгуулах баримт бичиг энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй;

19.1.3.өргөдөл гаргагч хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлснийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагч нь зөрчлийг арилгасны дараа бүртгүүлэх хүсэлт дахин гаргаж болно.

19.3.Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг өргөдөл гаргагч үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд гомдол гаргаж болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ЗАМААР ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ**

### **20 дугаар зүйл.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл гаргах**

20.1.Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь энэ хуулийн 13.3, 15.1, 16.1-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргана.





20.2.Өргөдөлд энэ хуулийн 15.2-т зааснаас гадна үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээдийн тухай мэдээллийг тусгана.

### **21 дүгээр зүйл. Улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардах баримт бичиг**

21.1.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

21.1.1. хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт;

21.1.2. баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

21.1.3. үүсгэн байгуулах баримт бичиг;

21.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

21.1.5. шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

21.1.6. энэ хуулийн 11.1.7-д заасан эрх залгамжлалын талаарх өөрчлөлтийг оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг;

21.1.7. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасны дагуу гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр.

21.2. Улсын бүртгэлийн байгууллага өргөдөл гаргагчаас энэ хуулийн 21.1-д зааснаас бусад баримт бичгийг шаардахгүй.

### **22 дугаар зүйл. Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх**

22.1. Хуулийн этгээдийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тохиолдолд нийлсэн хуулийн этгээд тус бүрийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож улсын бүртгэлээс хасах бөгөөд шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

22.2. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах тохиолдолд нэгдэж байгаа хуулийн этгээд тус бүрийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож улсын бүртгэлээс хасах бөгөөд нэгтгэж байгаа хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

22.3. Хуваах замаар өөрчлөн байгуулах тохиолдолд хуваагдаж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцож улсын бүртгэлээс хасах бөгөөд шинээр байгуулагдсан хуулийн этгээд тус бүрийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.



22.4.Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тохиолдолд шинээр байгуулагдсан хуулийн этгээд тус бүрийн бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

22.5.Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдөх тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож, шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛД ОРУУЛСАН  
ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ**

**23 дугаар зүйл.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан  
өөрчлөлтийг бүртгүүлэхэд шаардах  
баримт бичиг**

23.1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

23.1.1.нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт;

23.1.2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

23.1.3.үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр;

23.1.4.үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт;

23.1.5.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

23.1.6.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

23.2.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага өргөдөл гаргагчаас энэ хуулийн 23.1-д зааснаас бусад баримт бичгийг шаардахгүй.

23.3.Хуулийн этгээдийн эрх шилжүүлэх өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

23.3.1.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

23.3.2.эрх шилжүүлж байгаа тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр;

23.3.3.дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт;

23.3.4.Иргэний хуульд заасан холбогдох гэрээ;



23.3.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

23.4.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 13.3, 15.1, 16.1-д заасны дагуу гаргана.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТАТАН БУУЛГАСНЫГ  
УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ**

**24 дүгээр зүйл.Хуулийн этгээдийг татан буулгасан тухай  
улсын бүртгэлийн байгууллагад  
мэдэгдэх**

24.1.Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын гурван өдрийн дотор холбогдох улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргана.

24.2.Иргэний хуулийн 32.3-т заасны дагуу татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дараа уг хуулийн этгээдийг татан буулгаж дууссан тухай холбогдох улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

24.3.Энэ хуулийн 24.1-д заасан баримт бичгийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага тухайн хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

24.4.Хуулийн этгээдийг татан буулгасан тухай мэдээллийг улсын бүртгэлд бүртгэснээс хойш тухайн хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулахгүй.

**25 дугаар зүйл.Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын  
бүртгэлд бүртгүүлэхэд шаардах  
баримт бичиг**

25.1.Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэхэд Иргэний хуулийн 32.2-т заасан татан буулгах комисс дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- 25.1.1. баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- 25.1.2. татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;
- 25.1.3. дуусгалтын тайлан;
- 25.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;



25.1.5. татварын байцаагчийн акт, тодорхойлолт;

25.1.6. өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа.

25.2. Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 13.3, 15.1, 16.1-д заасны дагуу гаргана.

25.3. Хуулийн этгээдийг дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгасан тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ.

### **26 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгасныг бүртгэх**

26.1. Улсын бүртгэлийн байгууллага нь татан буугдсан хуулийн этгээдийн тухай мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулснаар тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанд тооцно.

26.2. Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухайгаа Иргэний хуулийн 32.11-д заасны дагуу цахим хуудсаар нийтэд тухай бүр мэдээлнэ.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

27.1. Энэ хуульд заасныг зөрчиж улсын бүртгэлд бүртгэсэн, ил тод байхаар хуульд зааснаас бусад улсын бүртгэлийн мэдээллийг задруулсан, эсхүл хууль зүйн үндэслэлгүйгээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан бол улсын бүртгэлийн байгууллагын ажилтан холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

27.2. Улсын бүртгэгч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг холбогдох улсын бүртгэлийн байгууллага хариуцан арилгана.

27.3. Хуулийн этгээдийн хувийн хэрэгт оруулах шаардлагатай энэ хуульд заасан баримт бичгийг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл буруу ташаа мэдээлэл ирүүлсэн зэргээс бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг холбогдох хуулийн этгээд буюу өргөдөл гаргагч хариуцан арилгана.



27.4.Хуулийн этгээд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн бол улсын бүртгэлийн байгууллага нь тухайн хуулийн этгээдийг татан буулгах талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

27.5.Хуулийн этгээд энэ хуулийн 11.3-т заасан хугацаанд өөрийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол шүүгч, эсхүл эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**28 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

28.1.Энэ хуулийг 2015 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2003 оны 05 дугаар сарын 23-ны өдөр баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1 дэх заалтад “ . Энэ заалт эд хөрөнгө, хуулийн этгээдийн мэдээлэлд хамаарахгүй” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.4.7. хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн;”

**3 дугаар зүйл.** Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх заалтын “, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.11, 5.4.13 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 4<sup>3</sup> дугаар зүйл нэмсүгэй:

“4<sup>3</sup> дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлийг улсын бүртгэлд бүртгэх

1. Үүсгэн байгуулагч нь үйлдвэрчний эвлэлийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлөө Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай



хуульд заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан өргөдөл, бусад шаардлагатай баримт бичгийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан үзээд, шаардлага хангасан бол үйлдвэрчний эвлэлийг ажлын хоёр өдрийн дотор улсын бүртгэлд бүртгэнэ.

3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйлдвэрчний эвлэлийг бүртгэхээс татгалзвал энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.”

**2 дугаар зүйл.**Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн “энэ хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 4<sup>3</sup> дугаар зүйлийн “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, 4<sup>4</sup> дүгээр зүйлийн “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 4<sup>3</sup> дугаар зүйлийн дугаарыг “4<sup>4</sup> дүгээр зүйл” гэж, 4<sup>4</sup> дүгээр зүйлийн дугаарыг “4<sup>5</sup> дугаар зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“23.2.Санхүүгийн тайланг зургаа ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад тушаагаагүй аж ахуйн нэгжийг улсын бүртгэлээс хасах талаар нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага хэвлэлээр нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш зургаан сарын дотор санал, гомдол гараагүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.34.“төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;”

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн “энэ хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж, 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Хуралд” гэсний дараа “болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Үүсгэн байгуулагчид танхимын дүрмийг баталснаас хойш 14 хоногийн дотор танхимыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг



улсын бүртгэлийн байгууллагад Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана.”

**2/9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Улсын бүртгэлийн байгууллага өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.”

**3 дугаар зүйл.**Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн бус байгууллагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Төрийн бус байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хууль зүйн яаманд” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, 23 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Хууль зүйн яам” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Банкны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай”<sup>3</sup> хуулийн 16, 20 дугаар зүйлд” гэснийг “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлд” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.7.“хуулийн этгээд” гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлсэн этгээдийг;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

<sup>3</sup>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 22 дугаарт нийтлэгдсэн.



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “улсын бүртгэлийн гэрчилгээ” гэснийг “хуулийн этгээдийн мэдээлэл” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Чөлөөт бүсийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.4.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ.”

**2 дугаар зүйл.**Чөлөөт бүсийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “баталгаатай” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.Соёлын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.3 дахь хэсэг нэмсүгэй:

“7.3.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь энэ хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хуулийн этгээдийн мэдээллээ шинэчилнэ.”

**2 дугаар зүйл.**Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:**

“5.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээд нь харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэхдээ харьяалах аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-т бүртгүүлнэ.”

**2/8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалт:**

“8.2.1.цагдаагийн байгууллага болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн он, сар, өдөр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар;”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



**“18 дугаар зүйл.Эрүүл мэндийн байгууллагыг  
улсын бүртгэлд бүртгэх**

18.1.Эрүүл мэндийн байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэнэ.

18.2.Эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “14.1-д” гэснийг “15.1-д” гэж, 9.2 дахь хэсгийн “14.2-т” гэснийг “15.2-т” гэж, 9.3 дахь хэсгийн “16.1-д” гэснийг “17.1-д” гэж тус тус өөрчилсүгэй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“6.1.Дээд боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “Улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ болон” гэснийг “Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж,” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, 17.7 дахь хэсгийн “ажлын гурван өдрийн” гэснийг “ажлын хоёр өдрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь заалтын “нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр,” гэснийг, 97 дугаар зүйлийн 97.1.1 дэх заалтын “, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хоршооны тухай хуулийн 2 дугаар зүйлийн “энэ хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “бүртгэх байгууллагад” гэсний дараа “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Хоршооны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.3.Улсын бүртгэлийн байгууллага нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл ажлын хоёр өдрийн дотор хоршоог улсын бүртгэлд бүртгэнэ.”

**3 дугаар зүйл.**Хоршооны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “хоёр хувь” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.**Хоршооны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалт, 11.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрийн бус байгууллагын тухай,” гэсний өмнө “, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай,” гэж нэмсүгэй.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“1/15 дугаар зүйлийн 15.7.1 дэх заалт:**

“15.7.1.их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх;”

**2/15 дугаар зүйлийн 15.7.4-15.7.6 дахь заалт:**

“15.7.4.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах;

15.7.5.мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх;

15.7.6.мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах;”

**2 дугаар зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “бүртгэх байгууллагад” гэснийг “татварын байгууллагад” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Компанийн тухай хууль” гэсний өмнө “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Санхүүгийн зохицуулах хороонд” гэсний дараа “болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нөхөрлөлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6/нөхөрлөл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээнд заасан үйл ажиллагаагаа эхлээгүй, үйл ажиллагаа нь эхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд тасалдсан тохиолдолд харьяалагдах татварын албаны тодорхойлолтыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлээс хассан,”

**2 дугаар зүйл.** Нөхөрлөлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж” гэснийг “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу бүртгүүлж” гэж, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “7 хоногийн дотор” гэснийг “хоёр хоногийн дотор” гэж, 13 дугаар зүйлийн “энэ хуульд заасан журмын” гэснийг “энэ хуульд болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын” гэж тус тус өөрчилсүгэй.



**3 дугаар зүйл.** Нөхөрлөлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “, тэдгээрийн өргөдлийг үндэслэн” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Нөхөрлөлийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалтын “байгууллагыг байгуулах” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “байгууллагыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж, “байгуулж” гэснийг “эрхэлж” гэж, 14.3 дахь хэсгийн “сургалтын байгууллага байгуулах” гэснийг “сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



**“22 дугаар зүйл.Улсын бүртгэлд бүртгэх**

22.1.Боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх асуудлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “бүртгүүлж, гэрчилгээ авсан” гэснийг “бүртгүүлсэн” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “байгууллагыг байгуулах” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх” гэж, 20.2 дахь хэсгийн “цэцэрлэгийг байгуулах” гэснийг “цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтын “цэцэрлэг байгуулахад тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх” гэснийг, 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалтын “цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх” гэснийг “цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“15 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн  
үйлчилгээнд хураах тэмдэгтийн  
хураамжийн хэмжээ**

15.1.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.1.1.хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 44 000 төгрөг;



15.1.2.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэхэд 20 000 төгрөг;

15.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 10 000 төгрөг;

15.1.4.улсын бүртгэлийн мэдээллээс лавлагаа олгоход 5 000 төгрөг.

15.2.Улс төрийн нам, шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.2.1.улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 60 000-150 000 төгрөг;

15.2.2.улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 20 000-50 000 төгрөг;

15.2.3.шашны байгууллагыг бүртгэхэд 200 000 төгрөг;

15.2.4.шашны байгууллагын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 40 000 төгрөг;

15.2.5.шашны байгууллагын гэрчилгээний хугацаа сунгахад 80 000 төгрөг.

15.3.Гадаадын байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.3.1.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэхэд 1 100 000 төгрөг;

15.3.2.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 750 000 төгрөг;

15.3.3.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд 35 000 төгрөг;

15.3.4.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 40 000 төгрөг;

15.3.5.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хугацаа сунгахад 750 000 төгрөг;



15.3.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацаа сунгахад 75 000 төгрөг;

15.3.7.гадаадын хөрөнгө оруулалттай банкны төлөөлөгчийн газрыг бүртгүүлэхэд 1 800 000 төгрөг.”

**2 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 14, 16 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



**1/6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалт:**

“6.6.2.аж ахуйн нэгжид гэрчилгээ олгох.”

**2/6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг:**

“6.7.Иргэн, аж ахуйн нэгжид олгох гэрчилгээний загварыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**3/6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг:**

“6.9.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүртгэл, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд улирал бүр мэдээлж байна.”

**2 дугаар зүйл.**Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” хуулийн 7.1.1-д заасан байгууллага /цаашид “бүртгэх байгууллага” гэх/-д” гэснийг “жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, 6.6, 6.8 дахь хэсгийн “бүртгэх байгууллага” гэснийг “жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Бүртгэх байгууллага” гэснийг “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-

<sup>8</sup>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 22 дугаарт нийтлэгдсэн.





ийг дагаж мөрдөхөөс өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэл хүчин төгөлдөр байна.

**2 дугаар зүйл.** 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөхөөс өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн хувийн хэрэг, улсын бүртгэлтэй холбогдох бусад материал нь улсын бүртгэлийн мэдээллийн эх сурвалжийн бүрэлдэхүүн хэсэг болно.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэнийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь заалтад заасан даатгалд төрөөс даатгуулна.”

**2/16 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэг:**

“9.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувиар тооцон улсын төсвөөс жил бүр нийгмийн даатгалын санд төлнө.

10.Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох орлогын хэмжээ, шимтгэл төлөх журмыг Засгийн газар батална.”



**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт:**

“1/өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;”

**2/4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна. Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна.”

**3/12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Нийгмийн даатгалын сангийн төсвийг Төсвийн тухай хуулийн 8.4-т заасан цаглабрын дагуу боловсруулж, батална. Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

**4/13 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэг:**

“1.Сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн улирлын болон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабрын дагуу боловсруулж, тайлагнана.

2.Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн хагас жилийн болон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасан цаглабрын дагуу, нийгмийн даатгалын төв байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цаглабрын дагуу тус тус боловсруулна.



3.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь нийгмийн даатгалын сангийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, нийгмийн даатгалын сангийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор хянан хэлэлцэж, нийтэд мэдээлнэ.

4.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл /зарлагаас давсан орлого/-ийг тухайн сан тус бүрийн нийгмийн даатгалын төв байгууллагын дансанд төвлөрүүлж байна. Тухайн сангийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа сард шилжүүлэн зарцуулах шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын төв байгууллагаас зөвшөөрөл авна.”

**5/15 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:**

“6.Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

7.Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно.”

**6/16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.”

**7/16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Ажил олгогч нь тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр тайлагнана.”



**8/16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ сар, улирал, хагас жил, жилээр гэрээний дагуу төлнө.”

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын “гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл/-ийн” гэснийг “гишүүдийн” гэж, 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “2 дахь” гэснийг “3 дахь” гэж, 13 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсгийн дугаарыг “5, 6” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ  
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-т заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний 2 тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан 2 даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлсний нийлбэрээс энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хувь хэмжээгээр бодож тогтооно.”

**2/22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан



нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно.”

### **3/28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:**

“2/авч байгаа тэтгэврийг нь тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлсний хэмжээг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой уялдуулан хөдөлмөрийн хөлсний хэмжээ өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдож тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан бол зөвхөн нэг удаа;”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.”

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, 15 дугаар зүйлийн “16” гэснийг “19” гэж, 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтын “6 долоо хоногийн” гэснийг “6 сарын” гэж, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3 дахь заалтын дугаарыг “3-4” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 15 дугаар зүйлийн “/сургуульд суралцаж байгаа бол 19 нас/” гэснийг, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “сүүлийн” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС  
ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ,  
ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас 12 сар тутамд 1.5 хувиар бодож нэмэгдүүлэн тогтооно.”

**2/17 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын үйлчилгээнд хамруулах журмыг нийгмийн даатгалын төв байгууллага батална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 01 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ  
АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:



“3.Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “14 хоногийн дотор” гэсний дараа “, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 хүртэл сарын дотор” гэж, 7 дугаар зүйлийн “2” гэсний дараа “хүртэлх” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“4 дүгээр зүйл.Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа**

1.Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрийн хугацаанд олгоно.”

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6 сар” гэснийг “12 сар” гэж, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газраас” гэснийг “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 02 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Соёлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:



**1/3 дугаар зүйлийн 5-7 дахь заалт:**

“5/“уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэг” гэж уран сайхны кино, теле жүжиг, телевизийн олон ангит кино, хөгжөөнт хөтөлбөр, тоглолт, баримтат болон хүүхэлдэйн кино, газар зүй, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, зан үйл, соёлын өвийг тайлбарлан таниулсан аливаа бүтээл ба сэтгүүл зүйн бусад төрөл жанрын бүтээлийг;

6/“үндэсний нэвтрүүлэг” гэж телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа тухайн нэвтрүүлгийн зохиолч, ерөнхий найруулагч, продюссерийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, сурвалжлах багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн бүтээлийг;

7/“үндэсний кино” гэж зохиолч, ерөнхий найруулагч, продюссерийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, эвлүүлгийн багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн киног.”

**2/19 дүгээр зүйлийн 5-7 дахь хэсэг:**

“5.Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн 70 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

6.Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

7.Кино театр, үзвэрийн цэгээр сар тутам түгээх кинонд үндэсний киноны эзлэх хувь, интернет протоколд суурилсан телевиз /Ай-Пи телевиз/-ийн уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн видео санд байршсан нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

#### **1/10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсэг:**

“10.5.Цөмийн энергийн комисс ажлын албатай байна.

10.6.Ажлын албаны дарга бөгөөд Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.”

#### **2/ 11<sup>1</sup>, 11<sup>2</sup> дугаар зүйл:**

**“11<sup>1</sup> дүгээр зүйл.Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн  
төрийн захиргааны байгууллагын  
бүрэн эрх**

11<sup>1</sup>.1.Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11<sup>1</sup>.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11<sup>1</sup>.1.2.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журам, заавар, стандартыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11<sup>1</sup>.1.3.цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11<sup>1</sup>.1.4.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, баримт бичгийг холбогдох этгээдээс үнэ төлбөргүй гаргуулж авах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтнийг хяналт шалгалтад татан оролцуулах;



11<sup>1</sup>.1.5.цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтөлж, цацрагтай ажиллагчийн өртөж байгаа мэргэжлийн шарлагын тунд хяналт тавих, шарлагын тунгийн мэдээллийн сан бүрдүүлэх;

11<sup>1</sup>.1.6.үйлдвэрлэл, судалгаа, оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих;

11<sup>1</sup>.1.7.улсын хилээр нэвтрүүлэх цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах;

11<sup>1</sup>.1.8.хүрээлэн байгаа орчны болон ахуйн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшний хяналт шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх, чанарын баталгаажилтыг хангах арга хэмжээ авах;

11<sup>1</sup>.1.9.хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох олон улсын байгууллагаас мэргэжлийн тусалцаа, дэмжлэг авах;

11<sup>1</sup>.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **11<sup>2</sup> дугаар зүйл.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

11<sup>2</sup>.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11<sup>2</sup>.1.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

11<sup>2</sup>.1.2.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11<sup>2</sup>.2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна.



11<sup>2</sup>.3.Энэ хуулийн 11<sup>2</sup>.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно.”

### **3/12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэг:**

“12.10.Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батална.”

**2 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.6-28.2.8 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1.9 дэх заалтын “төрийн захиргааны” гэсний өмнө “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэж, 28 дугаар зүйлийн 28.4.4, 28.4.5, 28.6.5 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний өмнө “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн” гэж, 50 дугаар зүйлийн 50.1.3 дахь заалтын “зөрчлийн тохиолдлыг” гэсний дараа “Цөмийн энергийн комисс, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/11 дүгээр зүйл:**

#### **“11 дүгээр зүйл.Цөмийн энергийн комиссын бүрэн эрх**

11.1.Цөмийн энергийн комисс дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11.1.2.энэ хуулийн 28.8-д заасан мэдээллийг нэгтгэн боловсруулж, шаардлагатай бол магадлан шалгаж Олон улсын атомын энергийн агентлагт зохих журмын дагуу хүргүүлэх;

11.1.3.цөмийн материалын тооллого, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөн хийх журмыг батлах;



11.1.4.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журмыг батлах;

11.1.5.гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

11.1.6.ураны баяжмал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн онцлогийг харгалзан түүний хүчин чадал, тоо хэмжээ, шилжилт хөдөлгөөн, тээвэрлэлтийн холбогдолтой нууцлах мэдээллийн жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

11.1.7.цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

11.1.8.улсын хэмжээнд ашиглаж байгаа ионжуулагч цацраг бүртгэх багаж, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, тохируулга хийх;

11.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.2.Цөмийн энергийн комисс нь цөмийн материал, цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай байгууламжтай байх бөгөөд уг байгууламж нь улсын онц чухал объект байна.

11.3.“Цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдал” гэж цөмийн төхөөрөмжөөс гарах цацраг идэвхт хаягдлаас бусад төрлийн цөмийн технологийн хэрэглээний хаягдлыг ойлгоно.”

**2/14, 15 дугаар зүйл:**

**“14 дүгээр зүйл.Хил хамгаалах болон гаалийн байгууллага, түүний албан тушаалтны бүрэн эрх**

14.1.Хил хамгаалах болон гаалийн байгууллага, түүний албан тушаалтан хяналт шалгалтаар илэрсэн, зохих зөвшөөрөлгүй цөмийн материал, цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар мэргэжлийн хяналтын болон хууль хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэж, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авна.



### **15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл**

15.1.Дараах үйл ажиллагааг Цөмийн энергийн комиссоос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.1.1.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.1.2.цөмийн төхөөрөмж ашиглах;

15.1.3.цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах;

15.1.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах.

15.2.Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;

15.2.2.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;

15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх.

15.3.Дараах үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.3.1.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах;

15.3.2.цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах;

15.3.3.цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох;

15.3.4.цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.”

### **3/18 дугаар зүйлийн 18.8, 18.9 дэх хэсэг:**

“18.8.Энэ хуулийн 15.1.1-15.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тагнуулын төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, энэ хуулийн



15.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн комисс, тагнуулын төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, энэ хуулийн 15.3-т заасан тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн комиссоос тус тус санал авсан байна.

18.9.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзээд тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг үйл ажиллагааны онцлогийг харгалзан энэ хуулийн 15.1, 15.2.2, 15.2.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6-12 сар, энэ хуулийн 15.2.1, 15.3.1, 15.3.2, 15.3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1-3 сарын дотор, энэ хуулийн 15.3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3-14 хоногийн дотор шийдвэрлэнэ.”

#### **4/19 дүгээр зүйлийн 19.7, 19.8 дахь хэсэг:**

“19.7.Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.6-д заасан ажиллагаанаас гадна Ашигт малтмалын тухай хуулийн 26.2-т заасан ажиллагааг явуулна.

19.8.Тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь энэ тухай ажлын таван өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Цөмийн энергийн комисс, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага, олон нийтэд тус тус мэдээлнэ.”

**4 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 15.1.2, 15.1.5, 15.1.6-д заасан” гэснийг “Энэ хуулийн 15.1.2, 15.2.1, 15.2.2-т заасан” гэж, “хувьцаа эзэмшигчийн дараах асуудлаар гаргасан шийдвэр Цөмийн энергийн комиссын батламжилснаар хүчин төгөлдөр болно.” гэснийг “хувьцаа эзэмшигч нь дараах асуудлаар шийдвэр гаргахаас өмнө Цөмийн энергийн комиссоос зөвшөөрөл авна:” гэж, 7.4 дэх хэсгийн “цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь тухайн” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Төрийн” гэснийг “Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.10, 18.11 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4, 22.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1-26.3, 26.5, 26.7 дахь хэсгийн “Төрийн захиргааны” гэснийг “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий” гэж, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх

хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, мөн зүйлийн 27.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.10 дахь заалтын “төрийн захиргааны” гэснийг “тусгай зөвшөөрөл олгосон” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх заалтын “төрийн захиргааны” гэснийг “эрх бүхий” гэж, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1.3, 37.1.6, 37.2.3 дахь заалтын “төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Цөмийн энергийн комисст” гэж, 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийн “цөмийн энергийн” гэснийг “геологи, уул уурхайн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Төрийн захиргааны байгууллага” гэснийг “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “Төрийн захиргааны байгууллага” гэснийг “Цөмийн энергийн комисс” гэж, 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “Цөмийн энергийн комисс” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “комиссын удирдлага дор төрийн захиргааны байгууллага” гэснийг “комисс” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “төрийн захиргааны байгууллагаар” гэснийг “Цөмийн энергийн комиссоор” гэж, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 26.2.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, мөн зүйлийн 27.2 дахь хэсгийн “15.1.5, 15.1.6-д” гэснийг “15.2.1, 15.2.2-т” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “15.1.1-15.1.7-д” гэснийг “15.1, 15.2-т” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “15.1.8-д” гэснийг “15.3-т” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “15.1.1-15.1.4-т” гэснийг “15.1-д” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5.3 дахь заалтын “15.1.5-д” гэснийг “15.2.1-д” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3, 18.5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5.4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.5, 28.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “15.1.6-д” гэснийг “15.2.2-т” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “15.1.7, 15.1.8-д” гэснийг “15.2.3, 15.3-т” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “15.1.5-д” гэснийг “15.2.1-д” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “15.1.7-д” гэснийг “15.2.3-т” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “15.1-д” гэснийг “15 дугаар зүйлд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “15.1.1, 15.1.3-15.1.5, 15.1.7, 15.1.8-д” гэснийг “15.1.1, 15.1.3, 15.1.4, 15.2.1, 15.2.3, 15.3-т” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “15.1.2, 15.1.6-д” гэснийг “15.1.2, 15.2.2-т” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “15.1.1-15.1.4, 15.1.7, 15.1.8-д” гэснийг “15.1, 15.2.3, 15.3-т” гэж, 28 дугаар зүйлийн 28.3, 28.4 дэх хэсгийн “15.1.5-д” гэснийг “15.2.1-д” гэж, 30 дугаар зүйлийн 30.1



дэх хэсгийн “15.1.2, 15.1.5-15.1.7-д” гэснийг “15.1.2, 15.2-т” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “15.1.6, 15.1.7-д” гэснийг “15.2.2, 15.2.3-т” гэж, 38 дугаар зүйлийн 38.2, 38.3 дахь хэсгийн “ 11.3-т” гэснийг “11.2-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “орон тооны бус” гэснийг, 10.2 дахь хэсгийн “, Комиссын орлогч дарга нь цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.1, 28.6.2 дахь заалт, мөн зүйлийн 28.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 02 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, 11.1.16 дахь заалт, мөн зүйлийн 11.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.3, 21.1.4 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалтын “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.20 дахь заалтын “цацраг идэвхт болон” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;

2/“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын стратегийн зорилтыг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх.

3.“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд үүрэг болгосугай.



4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
12 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС БОЛОВСРОЛЫН ТАЛААР  
БАРИМТЛАХ БОДЛОГО  
/2014-2024 он/**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

1.2.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго нь иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино.

1.3.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

1.3.1.боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах;

1.3.2.боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх;



1.3.3.боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг бүтэц, байршил, онцлог хэв шинжид уялдуулан уян хатан тогтоож байх;

1.3.4.боловсролын удирдлагын бүх түвшинд төрийн болон орон нутгийн, мэргэжлийн, олон нийтийн төлөөллийн байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоог тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах;

1.3.5.боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг өргөтгөх.

### **Хоёр.Боловсролын хөгжлийн талаар баримтлах зарчим**

2.1.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1.иргэн бүрд үзүүлэх боловсролын үйлчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай, хүртээмжтэй байх;

2.1.2.уламжлалт зан заншил, түүх, соёлын онцлогийг шингээсэн ерөнхий боловсролыг иргэн бүр заавал эзэмших, малчин өрхийн хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг харгалзсан бодлого явуулах;

2.1.3.боловсролын үйл хэргийг төрийн зүгээс нэгдсэн бодлого зохицуулалт, санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, аж ахуйн нэгж, олон нийт, иргэдийн оролцоог дэмжин, ил тод, нээлттэй, хяналттай байлгах;

2.1.4.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, эрдмийн эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлс, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлыг хүндэтгэх;

2.1.5.боловсролын байгууллагын үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхалтаас ангид, иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн аюулгүй байдалд харшлахгүй байх;

2.1.6.боловсролын байгууллагын багш, ажилтан, суралцагчийн эрхийг хүндэтгэж, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;



2.1.7.боловсролын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй, нээлттэй, техник, технологийн дэвшилд суурилсан, залгамж холбоотой байх;

2.1.8.иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх;

2.1.9.албан болон албан бус боловсролын нийт байгууллагыг бүх насны иргэдийн боловсролын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх чадамжтай болгох;

2.1.10.бүх шатны боловсролын үйл ажиллагаанд иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хүмүүнлэг бус үзэл, онол сурталчлах, аль нэг нам, эвслийн үзэл суртал тулгах, мансууруулах бодис, хүн болон байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг зохион байгуулахыг хориглох.

### **Гурав.Боловсролын хөгжлийн стратеги, удирдлага, зохион байгуулалт**

3.1.Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

3.2.Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ.

3.3.Бага боловсролыг эх хэлний чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвших үе хэмээн хөгжүүлнэ.

3.4.Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ.

3.5.Бүрэн дунд боловсролыг сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ.



3.6. Дээд болон мэргэжлийн боловсрол нь хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс үндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг үндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ.

3.7. Бүрэн дунд, мэргэжлийн, дээд боловсролын агуулга, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тогтолцоог бүрдүүлнэ.

3.8. Боловсролын байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш шаардлага тавьж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.

3.9. Ерөнхий боловсрол нь 12 жилийн тогтолцоотой байх бөгөөд ерөнхий боловсрол эзэмших сургалтын тасралтгүй, залгамж чанарыг хангаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шатлал, бүтцийг баримтална.

3.10. Боловсролын байгууллагын орчинд суралцагчийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

3.11. Боловсролын салбарт гарч байгаа бүтээлч санал, санаачилга, үйл ажиллагааг дэмжин, түгээн дэлгэрүүлнэ.

3.12. Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ.

3.13. Боловсролын хөгжлийн стратегийг тодорхойлох, нийтлэг зохицуулалт хийхэд зөвлөх эрх бүхий мэргэжлийн гишүүдээс бүрдсэн боловсролын зөвлөлийг байгуулж, тогтвортой ажиллуулна.

3.14. Насан туршийн боловсролын үйлчилгээний төрөл, хэлбэр, сургалтын байгууллагыг өргөжүүлэн бэхжүүлнэ.

3.15. Боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдал, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагын академик эрх чөлөөг хангана.

3.16. Дээд боловсролын байгууллагын судалгааны үйл ажиллагааг дэмжинэ.

3.17. Дээд болон мэргэжлийн боловсролыг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулна.



3.18.Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ.

**Дөрөв.Боловсролын агуулга, стандарт, сургалтын технологи, чанарын үнэлгээ**

4.1.Иргэн бүрд насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл, боломжийг бүрдүүлэн, нас, бие, сэтгэцийн онцлог, авьяас, хүсэл, сонирхолд нийцүүлж мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин хөгжүүлнэ.

4.2.Боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн орон нутаг, үндэсний онцлогт суурилсан музей, кино, хэрэглэгдэхүүн, лабораторид түшиглэн үйлийн явцад суралцах боломжийг бүрдүүлэхэд бүх талын оролцоог хангана.

4.3.Боловсролын агуулга, стандарт, сургалтын технологи, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүн, сургалтын байгууллагын үйлчилгээнд тавих стандарт, шаардлагыг тогтвортой мөрдөн, чанар, үр дүнг тогтмол үнэлж зохицуулалт хийнэ.

4.4.Бүх шатны сургалтыг төрийн албан ёсны хэл, бичгээр явуулж, уламжлалт монгол бичгийн сургалт, хэрэглээг үе шаттай нэмэгдүүлнэ. Суралцагчдын дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал эх хэлээрээ бага боловсрол эзэмших нөхцөл, боломжоор хангаж, хос хэлний сургалтын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.5.Гадаад улсад амьдарч байгаа монгол хүүхдэд үндэсний боловсролын суурь чадамж эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.6.Бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.

4.7.Гадаад хэлний сургалтыг эх хэлний суурь чадамжийг бүрэн эзэмшүүлэхтэй уялдуулан зохион байгуулах ба сургуульд заах үндсэн гадаад хэл нь англи хэл байна.

4.8.Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, цөм хөтөлбөрийг төрөөс тогтоож, чанар, үр дүнг үнэлнэ.



4.9.Суралцагч бүрийн авьяас, чадвар, сонирхлыг харгалзан ахлах ангид стандартаас давсан агуулгаар сургалт зохион байгуулахыг дэмжинэ.

4.10.Бүх шатны боловсролын хөтөлбөрт сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулга, хэлбэрийг тодорхойлж хэрэгжүүлнэ.

4.11.Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ.

4.12.Дээд болон мэргэжлийн боловсролын чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх, олон улсын сургалтын хөтөлбөр, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.13.Дээд болон мэргэжлийн боловсролыг олон улсын нийтлэг жишгийг баримжаалан төрөл бүрийн хэв шинжтэйгээр хөгжүүлнэ.

#### **Тав.Хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоо**

5.1.Багш бэлтгэх сургалтын байгууллагын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулж, бүх талын дэмжлэг үзүүлнэ.

5.2.Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.

5.3.Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **Зургаа.Боловсролыг тогтвортой хөгжүүлэх эдийн засаг, санхүүжилтийн тогтолцоо**

6.1.Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээг үйлчилгээний стандарт, чанар, хүрэх үр дүнтэй уялдуулан тогтооно.

6.2.Боловсролын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох, зориулалтын дагуу үр өгөөжтэй ашиглана.



6.3.Багш, ажилтан, суралцагчийн хөгжлийг дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн уян хатан, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.

6.4.Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд үндэсний үйлдвэрлэл, хөрөнгө оруулагчдыг дэмжинэ.

6.5.Бүх шатны сургалтын байгууллагыг хүний нөөцийн хөгжил, хөрөнгө оруулалт, санхүүжилтээр дэмжсэн аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, иргэдийн бодит дэмжлэгийг хөхиүлэн дэмжинэ.

6.6.Боловсролын салбарын төсвийг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй уялдуулан тогтвортой нэмэгдүүлж, захиран зарцуулах эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ.

6.7.Сургуулийн өмнөх боловсролын үндсэн зардлыг төрөөс санхүүжүүлж, хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагч нь хуваалцах зарчмыг баримтална.

### **Долоо.Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа, бодлогын хэрэгжилт, үнэлгээ, шалгуур**

#### **А.Хамтын ажиллагаа, түншлэл:**

7.1.Иргэдийн насан туршийн боловсрол эзэмших үйл хэргийг хөгжүүлэхэд төр, дотоод, гадаадын олон нийт, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хувь нэмрийг хөхиүлэн дэмжиж, түншлэлийг өргөжүүлэн хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлнэ.

7.2.Олон улс, бүс нутгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, бодлогыг уялдуулан зохицуулна.

7.3.Дэлхийн болон олон улсын боловсролын төрөлжсөн байгууллагад гишүүнээр элсэх, салбар, нэгж байгуулах, конвенцид нэгдэн орохыг дэмжинэ.

#### **Б.Бодлогын хэрэгжилт, үнэлгээ:**

7.4.Боловсролын хууль, эрх зүйн баримт бичиг, хөгжлийн хөтөлбөр, бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд энэхүү бодлогыг иш үндэс болгож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.





7.5.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хоёр жил тутам Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хуралд тайлагнаж, боловсролын чанарын үр дүнд тогтмол үнэлэлт, дүгнэлт өгч байна.

### **В.Бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:**

7.6.Монгол хүүхэд бүр үндсэн, цагийн, улирлын, ээлжийн, явуулын багшийн, нүүдлийн зэрэг хэлбэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан байна.

7.7.Ерөнхий боловсролын сургалтын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай дүйцэхүйц үндэсний хөтөлбөрийг нэвтрүүлж, олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 2018-2019 оны хичээлийн жилд хамрагдсан байна.

7.8.Сурлагын амжилтын олон улсын чанарын үнэлгээний судалгаанд 2021 онд хамрагдана.

7.9.Ерөнхий боловсролын сургуульд заах арга зүй, сургалтын технологиор мэргэшсэн магистр зэрэгтэй багшийн эзлэх хувийг 70 хувьд хүргэнэ.

7.10.Ерөнхий боловсролын сургууль нэг ээлжээр хичээллэх боломж бүрдсэн байна.

7.11.Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг 2016-2017 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна.

7.12.Тэргүүлэх чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын 20-иос доошгүй хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн байна.

7.13.Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэсэн байна.

7.14.Боловсролд мэдээллийн технологи, нээлттэй агуулга, хөтөлбөрийг хөгжүүлсэн байна.



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар  
хот

### **“Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын 8.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.2.Монгол Улсад цөмийн энерги болон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах, цөмийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, цөмийн технологи нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, бүрдүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Цөмийн энергийн комисс хэрэгжүүлнэ.”

2.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

### **“Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2015 оны 02 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

**Улсын ерөнхий прокурорыг  
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Магванноровын Энх-Амгаланг Улсын Ерөнхий прокуророор томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2015 оны 2 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

**Хөрөнгө оруулалтын тухай, Монгол Улсын Их  
Хурлын тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай,  
Онц байдлын тухай, Хүний хөгжил сангийн тухай,  
Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн  
зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж,



Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Н.Жанцан, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны иргэн Р.Гончигдорж болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нар оролцлоо.

Хуралдаанаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Монгол Улсын иргэн Р.Гончигдорж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэлдээ:***

“... Монгол Улсын Их Хурлаас баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ.”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт “Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.”, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийг чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.”, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.”, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Анхдугаар чуулганаар энэ хуулийн 14.3.7-д заасан асуудлаар санал хураалт явуулж, нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн батална.”; “Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр



зүйлийн 4 дэх хэсэгт “Ард нийтийн санал асуулгаар шийдсэн асуудалд цаашид нэмэлт өөрчлөлт оруулах бол Улсын Их Хурлаар хэлэлцэж, нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.” гэж тус тус хуульчилсан байна.

... Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Жаран наймдугаар зүйлийн 2, Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтдаа үүнээс өөрөөр байх дэгийг тогтоож өгсөн болно. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт Улсын Их Хурал Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэхээр Улсын Их Хурал болон түүний Байнгын хорооны хуралдааны үйл ажиллагааны ерөнхий зарчмыг тогтоосон. Гэтэл дээр дурдсан хуулийн заалт Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонхиор асуудлыг шийдвэрлэх зарчмыг зөрчин асуудлыг шийдвэрлэх саналын илүү өндөр босго тогтоосноор Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

Иймд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудлыг хянан хэлэлцэж өгнө үү.” гэжээ.

***Хоёр. Иргэн Р.Гончигдоржийн мэдээлэлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“...1. Үндсэн хуулийн тулгуур зарчим, үзэл санааг гажуудуулахгүйгээр Үндсэн хуулийн заалтыг бусад хуулиар баяжуулан, хөгжүүлэх, нийгмийн харилцааг нарийвчлан зохицуулснаар Үндсэн хууль өөрөө амьдрах чадвартай байж, нийгмийн харилцааг зохицуулах үүргээ гүйцэтгэнэ. Улсын Их Хурал нь нийтийн эрх ашиг, сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрхийг хязгаарлахтай холбогдсон нөхцөл журмыг тогтоох, хууль тогтоогчдын төсвийн эрх мэдлийг хязгаарлах,



Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тусгайлан авч үзэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүдийн оролцоог илүү хангах зорилгоор дээрх хуулиудыг батлан гаргах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг нэмэгдүүлэн тогтоожээ. Энэхүү шаардлагыг бий болгосноор Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэтрүүлж байгаа хэрэг бус харин ардчиллын үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөөний тухай Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх тухай Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Нэхэмжлэл гаргагчийн үндэслэл болгосон Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу “Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. ...” гэсэн заалт дээрх нэр бүхий хуулиудыг хэлэлцэн батлах босго тогтоосонтой шууд болоод дам холбогдохгүй юм. Уг заалт нь Үндсэн хуульд тусгайлан тогтоосон Улсын Их Хурал тарах, тараах, ард нийтийн санал асуулгаар асуудлыг шийдвэрлэх, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бэхжүүлсэн нь бусад органик хуулиар тусгай босго тогтоохыг хориглосон хэрэг биш юм. Тусгайлсан босго тогтоох, төлөөллийг нэмэгдүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах цаг хугацааны хязгаарлалт тогтоож өгөх зэрэг нь дэлхийн улс орнуудын парламентын хууль тогтоох практикт байдаг нийтлэг жишиг юм. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуульд Конгресс болон Сенатын аль алинд нь 5 нөхцөл байдалд 2/3-ын буюу дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдэхийг шаарддаг хэдий ч ердийн хуулиар баталсан дэгээрээ бүх сенатын гишүүдийн 3/5 саналаар аливаа хэлэлцүүлгийг төгсгөх, Сенатын гишүүдийн 2/3-ын саналаар Сенатын дүрмийг түдгэлзүүлэх асуудлыг зохицуулсан байдаг.

2. Улсын Их Хурал нь төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхтэй. Парламент тодорхой асуудлыг бодлогын түвшинд онцгойлон авч үзэж, түүнийг батлах дэг, журам тогтоох нь энэхүү онцгой бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм. Парламентын шийдвэр гаргах олонхийн зарчмыг буюу Үндсэн хуулийн энэхүү ойлголтыг хөгжүүлэх, илүү өргөн агуулгаар баяжуулан, бүтээлчээр хэрэгжүүлэх, олонхийн өөрийнх нь хэлбэрүүд /ердийн, дийлэнхи, үнэмлэхүй олонх/-ийг тухайн асуудлын цар, хүрээ, нийгэмд үзүүлэх үр нөлөө, нөхцөл

байдалтай нь уялдуулан хууль тогтоох үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь улс орны хөгжил, хүний эрх, эрх чөлөө, нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтвортой байдлыг хангах улс орны язгуур эрх ашигтай холбоотой.

Нийгмийн хөгжил, улс орны язгуур эрх ашиг сонирхлыг хангах үүднээс ямар ч хууль өөрчлөгдөж болно. Үндсэн хууль ч бас баяжиж төгөлдөржиж байх ёстой ч аливаа хууль тогтоомжийг өөрчлөх шаардлага байгаа гэж үзвэл дийлэнх олонхиороо зөвшилцөл ойлголцлын замаар шийдээд явах боломж нээлттэй байгаа юм. Дээрх хуулиудад хэлэлцэн батлах босгыг тусгайлан тавьж өгсөн нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, түүн дотроо эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний хөгжлийн болон хүний эрх, эрх чөлөөг хангах бодлогоос урган гарч байгаа юм. Үндэсний язгуур ашиг сонирхлыг илэрхийлсэн эдгээр бодлого Үндсэн хуульд өөрт нь сууж өгсөн байдаг. Энэ ч утгаараа тийм бодлогын асуудлуудыг Улсын Их Хурал ердийн олонхийн буюу 39 гишүүн хүрэлцэн ирж, 20 гишүүн дэмжсэнээр шийдэх нь ард түмний төлөөллийг хангах оролцоо, хүлээн зөвшөөрөгдөх легитим чанарыг бууруулах эрсдэлтэй гэж үзэж, ядаж Улсын Их Хурлын нийт гишүүдийн 1/3 ба түүнээс дээш гишүүн дэмжсэнээр асуудал шийдэгддэг байх босгыг тавьж өгсөн болно.

Үндсэн хууль зөрчсөн талаарх мэдээлэлд дурдсан хуулийн заалтыг тус бүрд нь авч үзвэл:

1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ.” гэсэн заалтын талаар: Хөрөнгө оруулалтын тогтворгүй орчин, олон удаагийн өөрчлөлтөөс дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашиг хохирох, эрх зүйн баталгаа алдагдан, энэ нь гадаад талдаа Монгол Улсын нэр хүндэд муугаар нөлөөлөх, дотооддоо эдийн засгийн өсөлт буурч байгааг Улсын Их Хурал анхааралдаа авч Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн баталсан. Уг хуулийг тогтвортой мөрдөх нь урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих, түүнчлэн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тогтвортой орчинд үйл ажиллагаа явуулах хууль зүйн баталгаа болгож тухайн хуулийг батлах, өөрчлөлт оруулах босгыг өндрөөр тогтоосон.

2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт “Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.” гэсэн заалтын талаар: Татвар төлөгчдөөс татварын



орлогоор цуглуулсан хөрөнгийг хуваарилан зарцуулах хууль тогтоогчдын эрх мэдлийг төсвийн тусгай шаардлагыг бий болгох замаар хязгаарладаг олон улсын практикт тулгуурлан энэхүү хуулийг батлан гаргасан. Хууль тогтоогчдын төсөв захиран зарцуулах эрх хэмжээнд хязгаарлалт тогтоож байгаа тул энэ хуулийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн шаардлага өндөр байх ёстой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өрийн дээд хязгаарыг бэхжүүлж өгсөн байдаг учраас энэ асуудалд туйлын няхуур хандах шаардлагыг суулгаж өгсөн юм. Үүнийг шийдэхэд ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүдийн оролцож батлах хувийг нэмэгдүүлэн зааж өгснөөр ард түмний хяналт тэнцэл хангахад эерэгээр нөлөөлнө. Тэр тусмаа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт өнөөг хүртэл олон нийтийн маргаан, шүүмжлэл дагуулж буй үед энэ босго тогтоосон заалтууд хэрэгтэй байна.

3. Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.” гэсэн заалтын талаар: Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. ...” гэж заасан. Онц байдал зарлаж, эрх зүйн онцгой дэглэмийг тогтоон мөрдүүлэхийг Улсын Их Хурлын гишүүдийн дийлэнх олонхиор шийдвэрлэх асуудал гэж хууль тогтоогчид үзсэн.

4. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Анхдугаар чуулганаар энэ хуулийн 14.3.7-д заасан асуудлаар санал хураалт явуулж, нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн батална.” гэсэн заалтын талаар: Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасан. Улсын Их Хурал шинэ бүрэн эрхийн хугацаа эхэлснээр чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн батлах эсэх асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд үйл ажиллагааныхаа журмыг тогтоож байгаа тухайн асуудлыг Улсын Их Хурлын гишүүдийн төлөөллийг аль болох илүү оролцоотой байж шийдвэрлэх бодлогыг баримталсан. Улсын Их Хурлын ээлжит сонгууль бүрийн дараа засаглаж буй олонхи Улсын Их Хурлын дэгийг өөрсдөдөө тохируулан өөрчлөөд байвал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхээс эхлээд хууль хэлэлцэх, батлах, бусад асуудлыг шийдвэрлэх дэг тогтворгүй байдалд хүрэх ба үүнээс сэргийлсэн заалт юм.





5. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.” гэсэн заалтын талаар: Ашигт малтмалын орлогоос хуримтлал үүсгэж, түүнийг удирдах, захиран зарцуулах, иргэддээ тэгш хуваарилах зарчим, хүрээ, хязгаарлалтыг тогтоож, энэ журмыг батлах, өөрчлөлт оруулахад тавигдах шаардлагыг өндөржүүлэн тогтоосон.

6. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Ард нийтийн санал асуулгаар шийдсэн асуудалд цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах бол Улсын Их Хурлаар хэлэлцэж, нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.” гэсэн заалтын талаар: Ард нийтийн санал асуулгын тухай хуульд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулж болохоор заасан. Ард нийтийн санал асуулгын дүнг үндэслэн Улсын Их Хурал нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.” гэсэн заалтыг үндэслэх ёстой. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Үндсэн хуулийн энэхүү заалтыг үндэслэл болгожээ.

Хөрөнгө оруулалтын тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Онц байдлын тухай, Хүний хөгжил сангийн тухай, Монгол Улсын Их Хурлын тухай, Ард нийтийн санал асуулгын тухай хуулиудын холбогдох заалт нь Үндсэн хуульчилсан хууль, органик суурь хуулиуд юм. Ядахдаа эдгээр хууль аль болох тогтвортой байхаас хууль тогтоох эрх мэдэл, улсын эдийн засаг, төсвийн тогтвортой бодлого, иргэддээ хийж буй нийгмийн хөрөнгө оруулалт, иргэдийн аюулгүй байдал, төрийн хэрэгт оролцох шууд ардчиллын үр дүн тогтвортой байх юм. Иймд дээрх хуулиудын холбогдох заалт Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр уламжилж байна.” гэжээ.

### **ҮНДЭСЛЭЛ:**

1. 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд



оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” хэмээн заасан. Энэ хэсгийг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ.” хэмээн өөрчлөн найруулсан байна.

2. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс үзвэл хууль тогтоогч хуралдааны ирцийн өндөр хувиас шалтгаалж, Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангахад бэрхшээл учирч байсныг харгалзан Улсын Их Хурлын хуралдааны ирц хүчинтэй байх хувийг 50+1 болгон, тэдгээрийн олонхийн саналаар буюу мөн 50+1 хувийн саналаар асуудлыг хэлэлцэн батлахаар босгыг бууруулахыг зорьж Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг өөрчлөн найруулжээ.

3. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт асуудлыг шийдвэрлэх саналын илүү өндөр босго тогтоосноороо Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ.”, Монгол



Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Анхдугаар чуулганаар энэ хуулийн 14.3.7-д заасан асуудлаар санал хураалт явуулж, нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн батална.” гэсний “...нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь...” гэсэн нь; Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт “Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.”, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.”, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.” гэсний “...хуралдаанд оролцсон ... гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь...” гэсэн нь; Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Ард нийтийн санал асуулгаар шийдсэн асуудалд цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах бол Улсын Их Хурлаар хэлэлцэж, нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.” гэсний “...нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй...” гэсэн нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ...” гэснийг зөрчсөн байна.

2. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ.”, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Анхдугаар чуулганаар энэ хуулийн 14.3.7-д заасан асуудлаар санал хураалт явуулж, нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн батална.” гэсний “...нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь...” гэсэн нь; Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт “Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.”, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.”,



Хүний хөгжил сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.” гэсний “... хуралдаанд оролцсон ... гишүүдийн гуравны хоёроос доошгүй...” гэсэн нь; Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Ард нийтийн санал асуулгаар шийдсэн асуудалд цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах бол Улсын Их Хурлаар хэлэлцэж, нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.” гэсний “...нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй...” гэснийг тус тус Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Ж.АМАРСАНАА**

**ГИШҮҮД**

**П.ОЧИРБАТ**

**Н.ЖАНЦАН**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 6.75

**Индекс: 14003**